



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
“ДАРХАН ЭРДЭС ШОХОЙТ ШИЙР” ХХК  
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дархан-Уул аймаг

## 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

- 1. КОМПАНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**
- 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН  
ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**
- 3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**
- 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**
  - 4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
  - 4.2 Орчны тохижилт-цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө-Ногоон байгууламж
  - 4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
  - 4.4 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө
  - 4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
  - 4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
  - 4.7 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
  - 4.8 БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө
- 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН  
ТӨСӨВ**

## 1. КОМПАНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТӨСЛИЙН НЭР

“Замын эрдэс нунтаг үйлдвэрлэл”

### 1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт Шийрийн хөндийн адагт Цохио Толгойн шохойн чулууны 2-р ордод байрлалтай Компаниас Шохойн чулууны ордоос үйлдвэрийн түүхий эдээ авч, тээрэмдэж байгаль орчинд халгүй технолиогоор үйлдвэрлэлээ явуулахад төслийн гол зорилго оршино.

### 1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР

“Дархан Эрдэс Шохойт Шийр ” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 1911017100

Регистрийн дугаар: 4264959

### 1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ

Дархан-Уул аймаг, Дархан сум 8-р баг 12-63 тоот

### 1.5 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Дархан уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийд 3 га талбай бүхий газар,  
Дархан хотоос зүүн хойд зүгт 8км зайд байрладаг

Солбицол:

Хүснэгт 1

№	X	Y	Урт
1	574555.44	5476478.48	164.27
2	574583.24	5476640.32	164.95
3	574734.33	5476574.28	166.52
4	574822.17	5476432.87	270.69

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг Дархан-Уул аймгийн Төмөрлөгийн үйлдвэр болон Улаанбаатар хотын Барилга архитектур корпораци итгэмжлэгдсэн лаборатороор тодорхойлуулан ажилладаг болно.

Шохой, магни /эрдэс, замаск/ гөлтгөнө болон холимог барьцалдуулагч бүхий барилгын материалыг үйлдвэрлэн хүргэж байна.

## ШОХОЙН ЧУЛУУ ТЭЭРЭМДЭХ

Зураг 1



Зураг 2



### а) Үйлдвэрийн танилцуулга

- “ДЭШШ” ХХК нь 2013 онд байгуулагдсан бөгөөд 2017 оноос эхлэн Хонгор сумын Шийрийн хөндийд үйл ажиллагаа явуулж байна. Манай компани нь барилгын материалын бэлдэц, замын эрдэс үйлдвэрлэх, Шохойн чулуу бутлаж тээрэмдэж замаск гэх үндсэн чиглэлтэйгээр ажиллаж байна.
- Одоогийн байдлаар нийт 20 ажилтан албан хаагчидтай, ажиллах хүчний 80 гаруй хувь нь 25-45 насны залуучууд байдаг.
- Дархан-Уул аймгийн Хонгор сумын Шийрийн хөндийт 3 га газрыг ашиглаж байна.

### б) Төслийн зохион байгуулалтууд, үйлдвэрийн бүтцийн товч танилцуулга

- Шохойн чулууг тээрэмдэх үйлдвэр
- Засвар үйлчилгээний хэсэг: засварын алба, сэлбэг хэрэгслийн агуулах,
- Компаний хашаанд: Ажилчдын байр, хоолны газар
- Компаний дэд бүтэц: Усан хангамж, цахилгаан хангамж

#### Шохойн чулуун үйлдвэрийн технологийн бүдүүвч

Зураг 3



Зураг 4



## 2. ОРОН НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

**Орон нутагт нөлөөлөх нөлөөллийг бууруулах:**

- ✓ Татвар, төлбөр тооцоог цаг тухайд нь хийж гүйцэтгэж байх
- ✓ Орон нутгийн иргэдийг сургаж ажлын байранд авч байх
- ✓ Төслийн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт чиглэсэн арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж байх
- ✓ Орон нутгийн иргэн, аж ахуй үйлчилгээг дэмжиж, хамтран ажиллах

**Орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ**

**Төслийн орчимд нутаглах орон нутгийн иргэд:**

- ✓ Орон нутгийн иргэдтэй уулзалт хийж байх
- ✓ Улирал бүр төслийн үйл ажиллагааны талаар тайлagnаж байх
- ✓ Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, төслийн үйл ажиллагаанд тусгаж, байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаж, жилийн эцэст тайлagnаж байх
- ✓ Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг хүндэтгэж байх
- ✓ Олон нийттэй харьцах, орон нутгийн харилцааны орон тооны үндсэн ажилтан авч ажиллуулах

**Төсөлд ажиллах ажилчдад чиглэсэн арга хэмжээ:**

- ✓ Орон тооны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны инженер авч ажиллуулах
- ✓ Эрүүл мэндийн урьчилан сэргийлэх үзлэгт ажиллагсадыг тогтмол хамруулж, холбогдох шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- ✓ Үйлдвэрийг хэвийн ажиллуулах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх аргын үндэс болсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг тогтмол өгч мөрдөлтөнд нь байнга хяналт тавих
- ✓ Ажилтан, ажиллагсад амны хаалт тогтмол хэрэглэж хэвших
- ✓ Дуу чимээ шингээгч ноос хөвөнгөөр хийсэн ажлын хувцастай байх ба ажиллагсадад чихэвч зүүлгэж хэвшүүлэх
- ✓ Үйлдвэрийн дотор ба гадна талбайг хяналтын камержуулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.
- ✓ Үйлдвэрийн хэсгүүдийн температур, чийгшил, тоосжилт, чимээ шуугианы түвшин зэргийг хянан мэдээлэх дохиоплын багажаар тоноглох
- ✓ Үйл ажиллагаа жигдэрч ажиллаж эхлээд мэргэжлийн байгууллагад хандан цехийн байр болон үйлдвэрийн байрны дотор ба гадна талд дуу шуугианы бохирдол, агаарт байх нянгийн тоо болон бусад үзүүлэлтүүдийг тодорхойлуулан ажлын байрны дүгнэлт гаргуулах

- ✓ Орчны мониторингийн болон эрүүл ахуйн байгууллагаар ажлын байруудад тухай бүр хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулж ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын талаар хамрагдаж байх.
- ✓ Үйлдвэрлэлийн осол, эрсдэлийн үеийн төлөвлөгөө боловсруулах
- ✓ Үйлдвэрийн ажилчдын орон тоонд ХАБЭАСургалтын инженерийн орон тоо заавал байлгах шаардлагатай бөгөөд “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө”-г жил бүр боловсруулан, орон нутгийн онцгой байдлын хэлтэст хянуулж батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай.
- ✓ Хөдөлмөр хамгааллын хэрэгслийг ажилчдад стандарт, хууль журмын дагуу тогтмол хангах. Энэ талаарх асуудлыг ХАБЭАСургалтын инженер бүрэн хариуцаж ажиллах.
- ✓ Байгаль орчин, үйлдвэрлэлийн экологийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажиллагсдыг сургалтанд хамруулах
- ✓ Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн өгч байх /хөдөлмөр хамгааллын инженерийн зааварчилгаагаар/ тус тус ажиллахаар төлөвлөж байна.

### **3. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг түүх соёлын дурсгал төсөлд хэргжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг гаргаж тусгав. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлож, тоон ба чанарын үнэлгээ өгнө.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс цаашид төсөл хэрэгжих явцад агаарын чанар, хөрсөн бүрхэвчийн бохирдолд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах тал дээр илүү түлхүү анхаарч, хяналт тавьж ажиллах шаардлагатай. Мөн гол сөрөг нөлөөллүүдийг доорх байдлаар нэгтгэн харуулав.

**3.1 Гол болон сөрөг нөлөөллийн үнэлгээний шалгуур ба анхаарвал зохих асуудлууд**

Хүснэгт 2

<b>Байгаль орчин/нийгмийн асуудлууд</b>	<b>Орон нутгийн хэмжээнд байгаль орчин, нийгэмд үзүүлж буй аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөлөл хамгийн их нөлөө үзүүлж байгаа асуудлыг хамгийн ноцтой асуудал гэж тооцно.</b>
<b>Байгаль орчин/нийгмийн элемент буюу нөлөөлөлд өртөж болзошгүй параметрүүд</b>	<p>Байгалийн физик шинж чанар: Агаарын чанар, чимээ шуугиан гадаргын усны төлөв байдал, чанар хөрсний чанар, геоморфологи биологийн буюу экологийн нөөц баялаг: Усны ургамал, амьтан, ургамал амьтан, тусгай хамгаалалттай газар нутаг, дархан цаазтай амьтан ургамлын төрөл зүйл Хүний хэрэглээний үнэ цэнэ: аж үйлдвэр, зам тээвэр, хөдөө аж ахуй, орон нутгийн усны хангамж орон нутаг дахь хаягдал усны менежмент, хог хаягдлын менежмент, эрчим хүчний хэрэглээ цахилгаан эрчим хүчний хангамж Амьдралын чанар: нийгмийн үнэ цэнэ, байгалийн үзэсгэлэн эрүүл мэнд аюулгүй байдал</p>
<b>Хууль эрх зүйн шаардлага</b>	<p>Тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх арга хэлбэрийг заасан журмуудыг батлан гаргана.</p>
<b>Байгаль орчны нөлөөллийн далайц</b>	<p>Замын эрдэс нунтаглах үйлдвэрлэх явцад болон түүхий эд материалыг тээвэрлэх явцад ойр орчимд тоосжилт үүсэх нөлөөлөлтэй.</p>
<b>Нөлөөлөл үүсэх газар зүйн байршил</b>	<p>Төсөл хэрэгжих талбай байрлаж буй газрын орчим тойронд өөр хэд хэдэн шохойн чулууны орд газар байрлаж байгаа. Мөн талбайн ойр хэд хэдэн тариалангийн талбай байна.</p>
<b>Нөлөөлөл үргэлжлэх хугацаа давтамж</b>	<p>Замын эрдэс нунтаг үйлдвэрлэл нь улирлын чанартай буюу жилд 6 сар ажиллана. Агаарт үүсэх тоосжилт нь түүхий эд материалыг тээвэрлэх явцад үүснэ. Мөн замын эрдэс нунтаг үйлдвэрлэлийн явцад тоног төхөөрөмжөөс дуу чимээ тархана. Тоосжилт болон дуу чимээ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад л тархах үргэлжлэх хугацаа богино байна.</p>
<b>Хүмүүст нөлөөлөх</b>	<p>Төсөл хэрэгжих талбай нь үйлдвэрлэлийн бүс ойр орчим</p>

байдал	зайд төслийн ажилчид, малчид, газар тариаланчид амьдарч байна. Төслийн дуу чимээ, тоосжилт нь эдгээр айл өрхөд нөлөөлнө.
Нөлөөллийн эрсдэл	Болзошгүй нөлөөлөлд тус үйлдвэрийн орчмын айл өрх болон ажилчид нөлөөлнө.
Нийгэм эдийн засгийн хувьд үзүүлэх нөлөө	Тухайн орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Ажлын байр нэмэгдэх, ажилгүйдлийн түвшин буурч, хүн амын амжиргаа дээшлэнэ. Мөн Дархан-Уул аймгийн бүтээн байгуулалтанд сайн чанарын олон улсын шаардлага хангасан дайргаар барилга байгууламж барихад дэмжлэг үзүүлнэ.
Нөхөн сэргээж болох эсэх	Ногоон байгууламж байхгүй бөгөөд цаашид ногоон байгууламжийн ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлж ургалтыг сайжруулах хэрэгтэй.
Нөлөөллийн нийт үнэлгээ	Нөлөөлөл дунд зэрэг боловч богино хугацаагаар үргэлжлэх эрсдэлтэй. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд сахиж ажиллах шаардлагатай

### 3.2 Төслийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

Хүснэгт 3

№	Болзошгүй нөлөөлөл	Бус нутгийн тувшинд	Аймгийн тувшинд	Сум буюу орон нутгийн тувшинд	Төслийн талбайн хэмжээнд	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Ур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	
	Агаарын чанарын өөрчлөлт	0	0	×	×	Агаар бохирдож болзошгүй

	Чимээ шуугиан	○	○	○	×	Төслийн талбайн хэмжээнд дуу чимээ ихсэх
	Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим	○	○	○	×	Төслийн талбайд 1 ширхэг гүний худаг бохирдож болзошгүй
	Хөрсний чанар, геоморфологи	○	○	×	×	Үйлдвэрлэлийн орчим талбай үйл ажиллаганаас улмаас хөрсөн бүрхэвч бохирдоно
2	Усны ургамал, амьтан	○	○	○	×	Төслийн талбайд ногоон байгууламжийн зорилгоор тарималжуулсан мод, өвслөг ургамлууд тоосжилтонд өртөнө.
	Эх, газрын ургамал амьтан	○	○	○	○	Ургамлын ургалт буурах эрдэлтэй
	Тусгай хамгаалалтай газар нутаг	○	○	○	○	
	Дархан цаазтай амьтан ургамлын төрөл зүйл	○	○	○	○	
3	Аж үйлдвэр зам тээвэр					Төслийн талбайн машины зогсоол, үйлдвэрийн талбайг цементээр хучих шаардлагатай
	Хөдөө аж ахуй	0	0	0	0	
	Орон нутгийн усны хангамж	○	○	○	×	Төсөл хэрэгжих талбай нь үйлдвэрлэлийн бүсэд хамаарч байгаа айл өрхийн малыг усалдаг
	Хаягдал усны менежмент	○	○	○	○	

	Хатуу хог хаягдлын менежмент	○	×	×	×	Ахуйн хог хаягдал доорх цэг хаяж төвлөрсөн хогийн цэгт НААҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хогийн цэгт хаядаг
	Эрчим хүчний хэрэглээ, хангамж	○	○	×	×	
4	Нийгэм-эдийн засгийн байдал	+	+	+	+	Ажлын байр, орлого нэмэгдэнэ
	Археологи, палеонтологи	○	○	○	○	
	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	○	○	○	×	Ажилчид тоосжилтой болон дуу чимээтэй орчинд ажиллаж чих дүлийрэх, уушигний өвчлөл тусах магадлалтай

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТУУД:

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болдог.

Бид энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартуудын дагуу төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлуудыг тооцон гаргасан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг компанийн удирдлага тухайн жилийн үйл ажиллагааныхаа зардалд тусган төлөвлөж зарцуулж байх нь зүйтэй. Бидний боловсруулсан байгаль хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.

### ➤ **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хууль зүйн үндэс**

Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай", "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай", "Газрын тосны бүтээгдэхүүний тухай", "Газрын тосны тухай", "Галын аюулгүй байдлын тухай", "Хэмжпийн нэгдмэл байдлыг хангах тухай", "Барилгын тухай", "Ариун цэврийн тухай", "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай", "Химийн хорт бодисоос хамгаалах тухай", "Авто тээврийн тухай" хуулиуд болон Засгийн Газар, БОАЖЯ болон бусад яамнаас гаргасан холбогдох заавар журмын дагуу боловсруулав. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд одоогийн төлөвлөсөн хүчин чадлын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хугацаанд уг төлөвлөгөө хүчин төгөлдөр байна.

- Байгаль орчин, техник технологийн асуудал
- Төслийн үндсэн үйл ажиллагаа

Төслөөс гарах хаягдлыг хадгалах, зайлцуулах, орчны бохирдлыг багасгах, гал түймэр болон бусад осол аюулаас сэргийлэх арга технологийг тайлангийн зохих хэсгүүдэд тусгасан болно.

- Байгаль орчин-нийгэм, эдийн засгийн асуудал

Төсөл хэрэгжсэнээр орон нутгийн иргэд ажлын байраар хангагдахын зэрэгцээ орон нутгийн төсөвт тодорхой хувь нэмэр оруулна.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээх, байгаль хамгаалах зардлыг тус компани өөрийнхөө үйл ажиллагааны зардалд оруулан тооцож байна.

Байгаль орчин-Удирдлага зохион байгуулалтын ажил

Байгаль орчныг нөхөн сэргээх ажлын хүрээнд зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ тэдгээрт шаардагдах хөрөнгийн хэмжээг тусгасан эрх бүхий байгууллагаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хийх шаардлагатай.

**4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Хүснэгт 4

<b>№</b>	<b>Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл</b>	<b>Хамрах хүрээ</b>	<b>Тоо, хэмжээ</b>	<b>Авч хэрэгжүүлэх арга хэмжээ</b>
1	Төсөл хэрэгжих талбайд олон тооны том оврын машин зорчих ба тэдгээрээс агаарт их хэмжээний тоосжилт үүсэх	Ашиглалтын талбай дотор	3га	Төсөл хэрэгжих талбайн автомашины зогсоол болон автозамын хэсгүүдийг хатуу хучилттай болгох, засвар үйлчилгээ хийх
2	Үйлдвэрт хэрэглэгдэх түүхий эд/ шохойн чулуу/ Хадгалах хураах талбайгаас салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх	Түүхий эд хадгалах хураах талбай	700 м2	Шохийн хадгалах талбайд хаалт хамгаалалт хийх
3	Дуу чимээний болзошгүй сөрөг нөлөөлөл	Үйлдвэрлэлийн явцад ажиллах тоног төхөөрөмжүүд	4 цэгт	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах
4	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгайллан бэлдсэн цэгт хаяагүй, тогтсон хугацаанд ачуулж, ариутгал хийгдээгүйгээс орчны агаар бохирдох	Үйлдвэрийн талбай болон ойр орчимд	2,7тн	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях зохих шаардлага хангасан битүүмжлэлтэй хогийн цэг хийх, хогийн цэгийн тогтмол ариутгал хийх
5	Үйлдвэрлэлийн ажиллагаанд ашиглагдаг тээврийн хэрэгслүүдээс агаар орчин бохирдох	Үйл ажиллагаанд ашигладаг тээврийн хээгсэл	3	Тээврийн хэрэгсэлүүдийг тогтмол үзлэг оношлогоонд хамруулах, утаанд хяналт тавьж ажиллах засвар үйлчилгээг тогтмол

				хийх
6	Шатах тослох материал асгарснаас хөрсөн бүрхэвч бохирдох	Засварын газар болон машины зогсоолын талбай	Машины зогсоол оролцоогоор талбай	Шатахуун түгээх цэгийн ойр орчмын талбайг болон автомашины зогсоолын талбайг бүхэлд нь хатуу хучилттай болгох Борооны ус зайлцуулагчтай байх
7	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдаас хөрсөн бүрхэвч бохирдох	Үйлдвэрийн талбай	1	Хуурай хог хаягдал хаях цэгийн өнгөн хөрсийг хуулж 10-20 см зузаан бетонон хучилт хийж ус нэвчихгүй болгох, салхиар дамжин хийсэхгүй битүүмжлэн хийх, ангилан ялгаж хийх Тухай бүрд нь хогоо холбогдох байгууллагаар тээвэрлүүлэх
8	Газрын гадарга механик эвдрэлд орж үржил шимгүй болох	Үйлдвэрийн талбайд	2000м2	Барилга байгууламж, зам талбайгаас бусад талбайн хөрсийг тэгшилж бэлтгэх, шимт хөрсөөр хучих
9	ХАБЭА-н дүрэм, урмыг биелүүлээгүйн улмаас байгаль орчинд хохирол учруулах	Үйлдвэрийн ажилчид	нийт	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, мэдээллийг хийх

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан

сэргийлэх, үр дагаварыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 5

Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Хамрах хувь сэжжээн хэмжэх	Жиен хэмжэх	Тоо хэмжэх	Нэгжийн үнэлгээ	Хэрэгжүүлэгч	Авч хэрэг жүүлэх арга хэмжээ	Баримтлах хууль, журам, стандарт
Төсөл хэрэгжих талбайд олон тооны том оврын машин зорчих ба тэдгээрээс агаарт их хэмжээний тоосжилт үүсэх	Га	3		Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусган хэрэгжүүлэх	“Дархан эрдэс шохойт шийр” ХХК	Төсөл хэрэгжих талбайн автомашины зогсоол болон автозамын хэсгүүдийг хатуу хучилттай болгох, засвар үйлчилгээ хийх	“Агаарын тухай” болон “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль/2012.05.17 / MNS 0017-2-3-16:1998  (Суурьшилын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
үйлдвэрт хэрэглэгдэх түүхий эд /шохойн чулгуу/ хадгалах, хураах талбайгаас салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх	Түүхий эд хадгалах, хураах талбай	M <sup>2</sup>	700	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусган хэрэгжүүлэх	“Дархан эрдэс шохойт шийр” ХХК	Шохой хадгалах талбайд хаалт, хамгаалалт хийх	Агаарын тухай болон агаарын бохирдлын хууль/2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998  “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль/2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998

#### **4.2 Орчны тохижилт-цэцэрлэгжүүлэлт төлөвлөгөө-ногоон байгууламжийн-**

Төслийн талбайн хашааны гадна болон дотор талаар мод тарьж ургуулна. Ашиглахгүй талбайн хөрсөнд олон настын зүлэгний үр тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна.

Зураг 6-7



Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд одоогийн төлөвлөсөн хүчин чадлын хэмжээнд үйл ажиллагаа явуулах хугацаанд уг төлөвлөгөө хүчин төгөлдөр байна.

Төслийн үндсэн үйл ажиллагаа

- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Байгаль орчныг нөхөн сэргээх ажлын хүрээнд зайлшгүй авч хэрэгжүүлэх

арга хэмжээ тэдгээрт шаардагдах хөрөнгийн хэмжээг тусгасан эрх бүхий байгууллагаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хийх шаардлагатай.

#### *Техникийн нөхөн сэргээлт*

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд төслийн талбайд үйлдвэрлэл явуулж байгаа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Үүнд:

- Үйлдвэрлэлийн зориулалтаар хийсэн хаалт, шороон овоолгийн хэрэггүйг нь тэгшилж засах замаар устгах хэрэгтэйг нь үргэлжлүүлэн ашиглах усжуулалтын сүлжээ болон бусад төрлийн гидротехникийн байгууламжуудыг нөхөн сэргээх
- Ногоон байгууламжийг нэмэхэд хөрс чулуулгийг халхавч давхаргаар дараа нь үржил шимт хөрсөөр хучиж тэгшлэх
- Үржил шимт хурдас ба хөрсөөр хучилт хийхийн өмнө бохирдсон хөрс болон хорт бодис агуулсан хурдас чулуулгийг хоргуйжүүлэх саармагжуулах арга хэмжээ авах

#### *Биологийн нөхөн сэргээлт*

Биологийн нөхөн сэргээлтийн үндсэн шаардлага нь нөхөн сэргээлтийг хийж байгаа тухайн нутгийн ургамлан нөмрөгийн үндсэн хэв шинжид ойртуулах явдал юм. Үүний тулд нөхөн сэргээлтэнд сонгож байгаа ургамлын төрөл зүйл нь тухайн нутгийн 50 км хүртлэх радиус доторх ургамлан нөмрөгийн төлөвшилттэй дүйцэж байх шаардлагатай.

Нөхөн сэргээлтийн үр дүнд тавих үндсэн шаардлага:

- Нөхөн сэргээсэн талбайн ургамлан нөмрөгийн зүйлийн бүрэлдэхүүн ойролцоо эвдрээгүй талбайн зүйлийн бүрэлдэхүүний 30%-д хүрсэн
- Нөхөн сэргээсэн талбайн ургамлан нөмрөгийн бүрхэцэд хүмүүнсэг ургамлын эзлэх хэмжээ


#### *Нөхөн сэргээж буй газрыг хамгаалах*


Салхины нөлөөгөөр хөрс элэгдэх явц нь хангалттай бус чийгшилттэй агаарын температур өндөр агаарын харьцангуй чийгшил бага байх, салхины үйлчлэл ихтэй хөрсний чийгшилт муу ургамлан бүрхэвчийг хамгаалах чадвар сул газруудад илүү түгээмэл ажиглагддаг. Түүнчлэн хөрс нь салхиар элэгдэх явц нь ган гачигтай цаг агаарын тааламжгүй үед илүү тохиолдоно.

## Ногоон байгууламж-орчинь тохиижилт-цэцэрлэгжүүлэлт төлөвлөгөө

Хүснэгт 6

№	Зорилт	Нэхэн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал Мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа
1	Ногоон байгууламж	модыг шинээр тарих	Шинэ талбайд тарих -Улиас -Хайлаас -Бургас	ш	1500	2500	2500.0	
2	Орчны тохиижилт	Хуучин тохиижилтийг сайжруулах	Үйлдвэрлэлийн талбайн тохиижилт	ш/кг	50/5	3000/30.0	300.0	
3	Цэцэрлэгжүүлэлт	Шинээр нэмж цэцэрлэгжүүлэх	Үйлдвэрийн талбайн ашиглаагүй хэсэгт олон наст тарих	кг	5	30.0	150.0	
<b>Нийт</b>							<b>2950.0</b>	





2 га талбай

2025 оны 1-4-р улиралд Хонгор сумын 1-р баг Үйлдвэрийн хашаанаас 30 метр зайд 1500 ширхэг мод тариж ургуулна. Үүнд

1. Бургас мод-600 ш
2. Агч мод-500 ш
3. Хайлаас мод-400 ш


Зураг 8-9

#### **4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Төслийн талбайд хамгийн ойр орших түүх, соёлын дурсгалт зүйл нь Дархан хотын төвд байрлах Морин хуур цогцолбор нэртэй түүх соёлын дурсгалт зүйл бөгөөд талбайгаас зүүн зүгт 3.5км-т оршино.

#### **Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх байдал, түүний үнэлгээ:**

Төслийн талбайгаас хамгийн ойр орших ТХГН нь хойд зүгт 80 км-т орших Тужийн нарс Байгалийн цогцолборт газар оршино. Иймд төслийн үйл ажиллагаанаас ТХГН-т сөрөг нөлөө үзүүлэхгүй.



Зураг 10. Төслийн талбайд ойр орших ТХГН

#### 4.4 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
1	Хатуу хог хаягдал, ахуйн химиин бодис, шатах тослох материалыар дамжин хөрсөн бүрхэвч бөхийндоо	Хатуу хог хаягдал, ахуйн химиин бодисыг эмх цэгтэй хадгалах /ДУА-ийн төвлөрсөн хог хаягдлын цэгт/	ДУА-ийн төвлөрсөн хогийн цэгт сард 1 удаа тээвэрлэж байх	100.0	MNS5344:2011 ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага, MNS4601:2011 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн. Техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо
		Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Төслийн талбайд байрлах авто зогсоолын талбайд	280.0	
2	Шороон шуурга, усны үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх	Цаг агаарын мэдээллийг өдөр бүр авч байх, төслийн талбайгаар дайран өнгөрч буй сайдр үерийн хамгаалалтын далан мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Тусгай зөвшөөрлийн талбайд		Үйл ажиллагааны зардалд
<b>Нийт</b>					<b>380.0</b>

#### 4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлыг бууруулах үр дүнтэй арга техникийг ашиглах замаар хог хаягдлын хэмжээг бууруулах нь төслийн нэг хэсэг юм. Хог хаягдлыг боловсруулах, устгах чиглэлээр стандартад нийцэхийн тулд дахин ашиглах, боловсруулан ашиглах үйл явцыг хэрэгжүүлэх нь нэн тэргүүн чухал байна.

- Үйлдвэрлэлийн явцад сав, баглаа боодлыг (жишээ нь хуванцар сав) устгах замаар хог хаягдлыг багасгах
- Ахуйн хог хаягдлыг бууруулах, боловсруулан дахин ашиглах зэрэгт чиглэгдсэн ажилчдад мэдлэг олгох кампанит ажлыг хэрэгжүүлэх

#### Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний төсөв

Хүснэгт

№	Хог хаягдлын ангилал	Серөг нөлөөллийг арилгах бууруулах	Серөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн
1	Ахуйн хог хаягдаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Үйлдвэрлэлийн орчимд хог хаягдалыг багасгах	Үйлдвэрийн хашаан дотор боон гаднай талбайд	1 машин	100.0	3	300.0	1 жил	
2	Ахуйн бохир ариутгах, халдвартгуйжуулж үлэх задлах бодис худалдаж авах	Өвчлөл, хурц хордлогын шалтгаан, түүнийг бууруулах ба БО-нд хохирол учруулахгүй	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. гал тогоонд ариутгал халдвартгуйжуулж лэлт хийлгэх Үйлдвэрийн талбайд	ширхэг	250.0	1	250.0	6-7 сард	
3	Хог хаягдлын сургалтанд хамрагдах	Сургалтаар хог хаягдлыг ангилан ялгаж БО-ыг бохирдлыг бууруулах	Үйлдвэрийн ажилчид үйлдвэрлэлийн талбайд	15	100.0	1	100.0	Жилд 1 удаа	
		Нийт /мян.төг/					650.0		

**Хог хаягдлын тухай сургалтын төлөвлөгөө**

Хүснэгт 8

<b>№</b>	<b>Нэр</b>	<b>Хамрагдах хүрээ</b>	<b>Хичээл цаг</b>	<b>Хичээл заах багшийн нэр</b>
1	Энгийн хог хаягдал ба аюултай хог хаягдлын тухай ойлголт	Нийт ажилчид	1	Байгаль орчны ажилтан
2	Хог хаягдлын ангилал, бүртгэл	Оффис ажилчид	1	НААҮГ
3	Хог хаягдлыг багасгах алхам	Нийт ажилчид	1	
4	Хог хаягдалтай холбоотой зөрчлүүн тухай хуулиас	Нийт ажилчид	1	БО-ны ажилтан
5	Аюултай хог хаягдлыг ангилах, хадгалах, устгах	Нийт ажилчид	1	
		Нийт	5	

**Хог цэвэрлэгээний төлөвлөгөө**

Хүснэгт 9

<b>№</b>	<b>Цэвэрлэгээ хийгдэх хэсэг</b>	<b>Хугацаа</b>	<b>Хамрагдах ажилчид</b>
1	Компаний хашаан дотор болон гадаа талбайг цэвэрлэнэ	Сар бүр	Нийт ажилчид
3	Дархан-Уул аймгийн бүх нийтийн цэвэрлэгээний ажилд оролцох	2023.05	Томилогдсон ажилчид болон техник хэрэгсэл
4	Дархан сумын хог цэвэрлэгээний ажилд оролцох	2023.05	Томилогдсон ажилчид болон техник хэрэгсэл
5	Үйлдвэрийн цех тасгийн хог цэвэрлэгээний ажил	Сар бүрийн	Үйлдвэрийн ажилчид
6	Компаний нийт ажилчдын цэвэрлэгээ	Улиралд 1 удаа	Нийт ажилчид

#### **4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Компани нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай.

##### **1. Агаарын бохирдол**

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт: Ажлын байрны агаар дахь тоосжилт болон бусад үзүүлэлтүүд
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр: Сорьц авч шинжилгээ хийх
- Байршил: төслийн талбай орчмын цэгүүдээс

##### **2. Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол**

- Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлт-Хөрсний геохимиин үзүүлэлт, бохирдолт
- Хяналт шинжилгээний төрөл, хэлбэр

Ашиглалтын хугацаанд хөрсний геохимиийн үзүүлэлтийг жилд хоёр удаа шинжлүүлэх

Зураг 11

#### **Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараалал**



✓

✓


✓ **Байгаль хамгаалах ажлын талаар:**

- Үйлдвэрийн ажилчдын ажиллах нөхцөл байдлыг хангах, байнга хяналт шалгалт хийх.
- Хог хаягдлыг удаан хурагцаагаар хадгалахгүй байх, гэрээний дагуу хугацаанд нь зайлцуулах
- Агаарын бохирдол болон бусад үзүүлэлтүүдийн шинжилгээг жилд 1 удаа байнга авч шинжлүүлэх. Ялангуяа тоос, дуу чимээ гэх мэт үзүүлэлтүүдийг нарийн тодорхойлуулах.
- Тос тослох материалыг хөрсөнд нэвчихээр ил задгай хаяхгүй байх . Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, тогтмол хяналт шалгалт хийх.
- Ургамалжуулж бут сөөг тарихдаа химиин гаралтай бодис бордоо хэрэглэхээс аль болох татгалзах.
- Ургамалжуулах зүлэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөгөөг авч ажиллах.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг жил бүр гүйцэтгэж, тухай бүр нь батлуулан хэрэгжүүлж ажиллах.
- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар тус тайлангийн бүлгүүдэд тусгасан заалт зөвлөмжүүдийг биелүүлж ажиллах арга хэмжээг авах

**ҮЙЛДВЭРИЙН ОРЧИНД ХЯНАЛТЫН ЦЭГҮҮДИЙГ БАЙГУУЛАХ**

1. агаарын бохирдлыг хянах 2 цэг /A, B /
2. хөрсний элэгдэл эвдрэл, талхагдал хянах 3 цэг /C, D, F/

Зураг12



**4.7 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах

Хүснэгт 11

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцсон төсөв /мян,төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Cap	Cap	Cap		
1	Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг ажиллагсдын тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	1000.0	3	6	9	Компаний удирдлага Байгаль орчны ажилтан	
2	Төслийн ашиглалтын явцад тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтыг байнга хийлгэж шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг тухай зохион байгуулах	1000.0	5	7	11		
	Нийт	2000.0					

#### 4.8 БОМТ-ИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Тайлангах оролцогч талууд	Тайлангах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлангах зардал, төг	Хариуцсан ажилтан	Зохион байгуулах газар
1	Дархан эрдэст шохойт шийр ХХК	Цаасан болон цахим	2025 онд БОМТайланг тайлагнана	2025 оны 10-р сард	250.0	Байгаль орчны ажилтан	Компаний байранд
	Нийт /мян.төг/				250.0		

#### 4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Байгаль орчныг тухайн жилд байгаль хамгаалах менежмент төлөвлөгөөнд нийт 5800.000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 6

№	Хэрэгжүүлэх ажил	Зардал мян, төг	Хугацаа	Хариуцах эзэн
<b>1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал</b>				
1.1	Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга замын талаар авах арга хэмжээ, зөвлөмж гаргах	700.0	2 улирал	4 улирал Компани
1.2	Дүйцүүлэни хамгаалах ажил зохион байгуулах	800.0	1 улирал	4 улирал Компани
<b>2. Ногоон байгууламж-орчны тохижилт-цэцэрлэгжүүлэлт нэмэгдүүлэх арга хэмжээний ажлын зардал</b>				
2.1	Төслийн бүс дотор зүлэгжүүлэлт хийн, мод бут тарьж тохижуулах	2500.0	2 улирал	4 улирал БО ажилтан
2.2	Дархан-Уул аймгийн БОАЖГ, УЦУОШТ хамтран ногоон байгууламж байгуулах, мод бут, байгаль хамгаалах сургалт зохион байгуулах олон нийтийн арга хэмжээнд оролцох /нийгмийн хариуцлагын хүрээнд/			
<b>3. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардал</b>				
3.1	Санамсар болгоомжгүй байдлаас үүдэн осол эндэгдэл гаргах	150.0	2 улирал	4 улирал БО ажилтан
<b>4. Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан зардал</b>				
4.1	НААҮГ-тай гэрээ байгуулан үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг тогтмол ачуулж, орчноо байнга цэвэр байлгах /	400.0	1 улирал	4 улирал компани
<b>5. Орчны шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын зардал</b>				
5.1	Хөрсний эвдрэл, бохирдол	450	2 улирал	2 улирал компани
5.2	Агаар бохирдлоос сэргийлэх	400		
5.3	Усны шинжилгээг хийлгэх	500		
<b>6. Удирдлагын зардал /Дүрэм , журам , төлөвлөгөөний шинэчлэл/</b>				
6.1	Үйл ажиллагаа явуулж байгаа чиглэлтэй холбоотой хууль дүрэм журамыг танилцуулах ажиллагааг нийт ажилчдын дунд зохион байгуулах	0.0	Жилд нэг удаа	2-3 улирал Компани
6.2	Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй бусад зардал	150.0	Жилд нэг удаа	2-3 улирал Компани
	<b>Нийт зардал</b>	<b>5800.0</b>		